

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

1. “Монголросцветмет” ТӨҮГ нь Баяжуулах фабрикийн хаягдлын аж ахуйн иж бүрэн мониторинг, аудит хийх, түүний цаашдын ашиглалтын төсөл, зөвлөмж боловсруулах ажил (тендерийн дугаар **МРЦМ/201908707**)-ыг хэрэгжүүлэх зорилгоор зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь “Монголросцветмет”ТӨҮГ-ийн Бор-Өндөр УБҮ-ийн баяжуулах фабрикийн хаягдлын аж ахуйн ашиглалтад хяналт, мониторинг хийж, цаашдын ашиглалтын төсөл, зөвлөмжийг боловсруулах ажлыг гүйцэтгэж, үйлдвэрлэлийн хэмжээ, бүтээмжийг өсгөх, ашиглалтын аюулгүй байдал, хүрээлэн буй орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулах, ашиглалтын хугацааг сунгахад чиглэгдэнэ.

3. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох мэдээллийг ирүүлнэ. Үүнд:

- ТӨХБАҮХАТухай хуулийн 14-16 дугаар зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан нотлох баримт. Үүнд:
 - Аж ахуйн нэгж, байгууллагын танилцуулга
 - Зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажилтнууд, удирдлагын мэдээлэл
 - Аж ахуйн нэгж, байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар батлуулсан хуулбар
 - Шүүхийн тодорхойлолт
 - ШШГЕГ-ын шийдвэр гүйцэтгэх албаны тодорхойлолт
 - Нийгмийн даатгалын албаны тодорхойлолт
 - 2018 оны санхүүгийн аудитлагдсан тайлан, дүгнэлтийн хамт
 - Татварын албаны татварын өргүй тухай тодорхойлолт
- Уулын баяжуулах үйлдвэрлэлийн хаягдлын аж ахуй, гидротехникийн байгууламжийн зураг төсөл боловсруулах, тухайн объектын ашиглалтын үе дэх мониторинг, аудит хийж гүйцэтгэхэд шаардагдах тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллага байх
- Уулын баяжуулах үйлдвэрлэлийн хаягдлын аж ахуй, гидротехникийн байгууламжийн зураг төсөл боловсруулах, тухайн объектын ашиглалтын үе дэх мониторинг, аудит, зохиогчийн хяналтын Гүйцэтгэгчээр ажилласан байх жилийн тоо: 2014-2018 онууд (Сүүлийн 5 жилд тухайн заасан чиглэлээр хийж гүйцэтгэсэн зураг төсөл, зөвлөх үйлчилгээний жагсаалт, гэрээний хуулбарыг гэрээ дүгнэсэн актын хамт ирүүлнэ)

Чадварыг нэмэгдүүлж сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно.

4. Гадаадын этгээд оролцох эрхтэй.

5. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг санал хүлээн авах эцсийн хугацаанаас нэг хоногийн өмнө дор дурдсан хаягаар ажлын өдрийн 09-16 цагийн хооронд авч болох бөгөөд мэдүүлгээ **2019 оны 10 дугаар сарын 4-ны өдрийн 15:00 цагаас өмнө цахим худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn** хаягаар ирүүлнэ.

“Монголросцветмет” ТӨҮГ

Хаяг:

Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 22-р хороо,

“Монголросцветмет”ТӨҮГ-ийн өөрийн байр, өрөө: 305

И-майл: mailbox@monros.mn

Утас: 458072, 453482, факс 458380